


“Харилцаа холбооны ажил”

Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд

Өндөр газар ажиллах, хүнд машин механизм

(1) Хүнийг унахаас хамгаалах системийн (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглээ


Ерөнхий дүрмийн дагуу Хүнийг унахаас хамгаалах иж бүрэн системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэ.



<Тусгай боловсрол>

Тусгай сургалтыг (4.5 цагийн лекц, 1.5 цагийн дадлага) ажлын тавцанг угсрахад хэцүү, хүнийг унахаас хамгаалах иж бүрэн системийг (олстой ажиллах шаардлагатай өндөр газруудыг оруулалгүй) ашиглах шаардлагатай 2м юмуу түүнээс өндөрт ажиллах гэж байгаа хүмүүст өгөх хэрэгтэй.

(2) Хамгаалалтын каск өмсөх




Каскны эрүү доорх оосрыг найдвартай чангална.



1. Өндөр газарт ажиллахад хамгаалалтын каскыг (хамгаалалтын каскын доторх хөөсөн полистерины доргилт шингээх жийрэгтэй) өмсөнө.
2. Хамгаалалтын каскыг ашиглахын тулд толгойны туузын уртыг толгойн ар талд тохируулах бөгөөд ажлын явцад холхихоос сэргийлэхийн тулд эрүү доорх оосрыг сайтар чангална.


(3) Багана дээр ажиллах



Анхаарах ёстой зүйл

1. Хэзээ олсгүй болох нөхцөл байдалд бүү ороорой.
2. Хамгаалалтын хаалт зэрэг унахаас сэргийлсэн хамгаалалтын төхөөрөмжийг ашигла.
3. D цагираг дээр хамгаалалтын хаалтын дэгээ тавих үед дуу чимээ, нүд, чиг заах, дуудахыг шалгаарай.


(4) Шаттай ажиллах



Анхаарах ёстой зүйл

1. Өндөр ба гүн нь 1.5м-с хэтэрсэн үед хамгаалалтын түр өргөгчийн төхөөрөмжийг суурилуул.
2. Мөргөлдөх осол гарах эрсдэлтэй үед хамгаалалтын шугамтай хүнийг унахаас хамгаалах төхөөрөмжийг хэрэглэ.
3. Шатыг тогтвортой нөхцөлд суурилуулна.
4. Шатны дээд хэсэг 60см-с илүү цухуйсан байна.
5. Хөлийн үзүүртээ хальтирдаггүй жигд интервалтай 30 см юмуу түүнээс өргөн шат ашигла.
6. Суурилуулах өнцөг 75° орчим байна.
7. Шатыг өөр ажилчид тулах ёстой.
8. Шатан дээр эсрэг ажил бүү хий.
9. Юм бариад дээш доош бүү яв.

(5) Өргүүрт тавцан дээр ажиллах



Анхаарах ёстой зүйл

1. Гарах хаалгаа өргүүрт тавцан болон байшингийн хооронд суурилуул.
2. Өргүүрт тавцан дээр материалыг бүү орхи.
3. Үзүүрийн зогсоогчийг суурилуул.
4. Босоо торыг суурилуул.
5. Ачаалсан ачаа нь төө тутамд 400кг юмуу түүнээс бага байх ёстой.
6. Тавцангийн өргөн нь 40см юмуу түүнээс илүү байх ёстой бөгөөд тавцан хоорондын зай нь 3см юмуу түүнээс бага байна.
7. Бүтцийн хавтанцар болон босоо баганын материалуудын хоорондын зөвшөөрөгдөх зай нь 12см-аас бага байна.
8. Өргүүрт тавцан дээр хүнийг унахаас хамгаалах систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэ.

(6) Багана босгох: Кран ажиллуулах гэрчилгээ шаардлагатай


Барилгын баганын ажилд ашиглах газар ухах шон ухах машин ажиллуулахын тулд барилгын автомашиныг жолоодох мэргэшил ба хөдөлгөөнт кран ажиллуулах мэргэжилтэй байх шаардлагатай. Үүнээс гадна татлагаар хийх ажлуудыг хийхийн тулд татлагын ажлын мэргэжилтэй байх ёстой.

| Ажил | Машины жин | Шаардлагатай мэргэшил |
|------------------------------------|--|---|
| Барилгын автомашиныг жолоодох ажил | 3 тонн юмуу түүнээс илүү даацтай барилгын автомашин (нягтруулагч машин ба бетон зуурмаг шахуургын машин) | Барилгын автомашин жолоодох ур чадварын сургалт |
| | нягтруулагч машин, бетон зуурмагийн машин, 3 тонноос доош даацтай барилгын зориулалттай машин | Барилгын автомашин жолоодох тусгай боловсрол |

| Ажил | Өргөх даац | Шаардлагатай мэргэшил |
|------------------------------|---|---|
| Хөдөлгөөнт краныг ажиллуулах | Өргөх даац нь 5 тонн ба түүнээс дээш | Хөдөлгөөнт краны оператор |
| | Өргөх даац нь 1 тонн ба түүнээс дээш эсвэл 5 тонноос доош | Жижиг оврын хөдөлгөөнт кран ажиллуулах ур чадварын сургалтын курс |
| Татлага | Өргөх даац нь 1 тонн ба түүнээс дээш | Татлагын ур чадварын сургалтын курс |
| | Өргөх даац нь 0,5 тонн ба түүнээс дээш эсвэл 1 тонноос доош | Татлагатай холбоотой тусгай боловсрол |

* Өргөх ачаа нь өргөх зүйлийн жин биш бөгөөд хөдөлгөөнт краны өргөх даац байна.

(7) Хүнд зүйл буулгах



Анхаарах ёстой зүйл

1. Ажлын талбарт орохыг хориглоно.
2. Ачааг газарт үлдээсэн бол ажлыг зогсоогоод байдлыг шалга.
3. Өргөсөн ачааны доогуур бүү ор.
4. Сумын шулуун зураасны өргөтгөл доор бүү зогс.

(8) Аюулгүй жолоодлогын үндсэн мэдлэг

1. Хамгаалалтын каск болон аюулгүйн хэрэгсэл зүүж хувцсаа шулуутган жолоод.
2. Жолооч нар өөрсдийн мэргэжлийн үнэмлэхээр жолоодно.
3. Ажиллагааг эхлүүлэхээс өмнө доголдол байхгүй эсэхийг шалгахын тулд тоормоз ба хоонс зэрэг асаах үзлэгийг хийсэн эсэхээ нягтал.
4. Жолоочийн суудал юмуу бусад газарт жолоочоос өөр хүн бүү суулга.
5. Тухайн тээврийн хэрэгсэлд суухдаа зориулалтын шат ба бариул ашигла.
6. Тээврийн хэрэгслийн их биеийг цэвэрхэн байлгаж, тостой гараар хөшүүргийг бүү ажиллуул.
7. Хөдөлгүүр ажиллаж байхад жолооч жолоочийн суудлыг эзэнгүй орхиж болохгүй.
8. Ажил зогссон юмуу дууссаны дараа өлгөөсийг газар луу буулгаж, хоонсыг салгаж, тоормозыг баттай бариулж, хөдөлгүүрээ зогсоож, түлхүүрээ аваад машинаа зохих газарт нь байрлуулна.

